

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖИЛ, ЧИГ ХАНДЛАГА ORIENTATION OF RESEARCH WORK OF LAW ENFORCEMENT UNIVERSITY



Ц.Цэрэндорж. ХСИС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн тэргүүн дэд захирал бөгөөд Шинжлэх ухаан, технологийн газрын дарга, удирдахуйн ухааны доктор, профессор, хурандаа
Tserendorj.Ts. Vice President of Science and Research Department Head of Science and Technology Department, Law Enforcement University, Ph.D, Professor, Colonel

Absrtact: It is discussed about current situation of science research work of University of innovation, law enforcement. This is focused and directed into the orientation and concept to develop of university like more research of university. This science, research work is sourced from the policy and direction of science and technology department of the university.

Нэг. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын өнөөгийн байдал

Өнөө үед улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн төвшинг тодорхойлох тулгуур ойлголт, үндсэн шалгуур үзүүлэлтэд шинжлэх ухаан, технологийн хөгжлийг тооцох болсон байна. Дэлхийн тэргүүлэх улс орны хөгжлийн байдлаас харахад бизнесийн байгууллагын өрсөлдөх чадварыг түүний технологийн түвшинтэй холбодог бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах чиглэлээр судалгаа, шинжилгээ байнга хийж, үр дүнг нь үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэглэдэг байгууллагыг менежмент сайтай байгууллага гэж үзэх болов.

XXI зуун нь даяарчлалын шинжтэй эрдэм мэдлэгийн буюу шинжлэх ухаан, технологи, мэдээллийн зуун болох учраас шинжлэх ухаан нь нийгмийн оюуны тэргүүлэгч хүчин зүйл болж, шинжлэх ухаан, технологи, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжиж хөгжүүлсэн улс орон л өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийнхээ бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдлаа дархлан хамгаалж, ард иргэд нь аз жаргалтай, нийгэм нь тогтвортой хөгжинө хэмээн бүх нийтээр итгэдэг боллоо.

Дэлхийн хөгжлийн хэтийн төлөвт нийцүүлэн манай их сургууль нь “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашгийг үнэнч шударгаар

хамгаалахад бэлэн, мэргэжлийн болон өндөр боловсрол, мэдлэгтэй, төрийн тусгай албаны шилэмэл бүрэлдэхүүнийг бэлтгэх, хууль сахиулах салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхэд оршино” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон.

Зорилгоо амьдралд хэрэгжүүлэхийн тулд боловсрол, шинжлэх ухааны талаар баримтлах төрийн бодлогод тулгуурлан, түүний үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн хүмүүнлэг, ардчилсан, эрх зүйт нийгмийг цогцлон бүрдүүлэх, төлөвшүүлэхэд шударга ёсыг тогтоох бат итгэл үнэмшилтэй, мэргэжлийн өндөр боловсрол, ур чадвартай, ёс суртахууны бүрэн төлөвшилтэй төрийн тусгай алба хаагч бэлтгэх, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг хангахаар чармайн ажиллаж байна.

Тус их сургуулийн үндсэн үүрэг, тэргүүлэх чиглэл нь эрдэмтэн, судлаач, багш нарын нөр их хүчин чармайлтаар гүйцэтгэдэг эрдэм шинжилгээ, судалгааны ажил мөн. Судалгааны ажил бол хууль сахиулах байгууллагуудын өмнө тулгамдаж буй нэн чухал асуудлыг тодорхой чиглэл зорилготой судлан шийдвэрлэх, нарийн зохион байгуулалттай бүтээлч үйл ажиллагаа юм. Харин түүний үр дүн нь онолын болон практикийн нотолгоо, баталгаа бүхий баримт хэрэглэгдэхүүн, тооцоолол, бүдүүвч, загварчлал, бодомж, дүгнэлтийг эрдэм шинжилгээний утга зүй,

үг найруулгаар бүтээн туурвиж, бүтээлийн тодорхой хэлбэрүүдээр илэрхийлэн гаргахыг хэлдэг билээ.

Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хэлбэрүүдэд: эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, зөвлөмж, даалгаварт болон төсөлт судалгааны ажил, нэг сэдэвт бүтээл, онолын ба практикийн бага хурлууд, реферат, төсөл, бакалавр, магистрын дипломын ажил, докторын диссертаци ордгийг бид бүхэн мэдэх билээ. Тиймээс, Хууль сахиулахын их сургуулийн профессор, багш, эрдэмтэд, сургуулийн үйл ажиллагааг дэмжигч ажилтнуудын хүчин чармайлтаар хийсэн ажлаас товчлон доор оруулав.

ХСИС нь эрдэм шинжилгээ, судалгааны их сургууль болох зорилтыг тэргүүлэх чиглэлээ болгон ажиллаж, энэ зорилтын хүрээнд Хууль зүйн яам болон түүний харьяа агентлаг, байгууллагуудаас ирүүлсэн захиалгын дагуу онол, арга зүй, практикт үндэслэн 13 даалгаварт онолын болон суурь судалгааны ажил хийв.

Тухайлбал, “Хорих ял эдлэгсдийг ажлын байраар хангах, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг барагдуулах нь”, “ХСИС-ийн Хилийн сургуулийн сургалтын чанарыг дээшлүүлэх арга зам”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иж бүрэн 3 судалгаа, “Цахим гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнтэй тэмцэх арга зам”, “Хил хамгаалах байгууллагад мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох нь”, “Хил хамгаалах ерөнхий газарт Е-оффисийг нэвтрүүлэх нь”, “Шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны орчин, түүнд хийх шинэтгэл”, “АНУ-ын Холбооны мөрдөх товчооны шүүхийн шинжээчдийн сургалтын бодлогын тогтолцоо” сэдэвт зэрэг судалгааны даалгаварт ажлыг хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсын шинэчлэлийн Засгийн газрын бодлого, шийдвэр, түүний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, эрдэм шинжилгээний ажлын цар хүрээг өргөжүүлэх, судалгааны ажлын үр нөлөөг практикт нэвтрүүлэх зорилгоор олон улсын сургалт семинар болон хууль сахиулах салбарын тулгамдсан асуудлыг хөндсөн олон улсын болон хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд 9, их сургуулийн хэмжээнд 20 гаруй эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, хурлын явцад судлаачдаас гарсан санал, шүүмжийг нэгтгэн зөвлөмж боловсруулж, илтгэлийн эмхэтгэл болгон хэвлүүлж, нийтийн хүртээл болгожээ.

Үүнд: тус их сургуулиас санаачлан УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүйн яам, ХБНГУ-ын Ханнс Зайделын сантай хамтран “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг амжилтай зохион байгууллаа. Хуралд дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, их, дээд сургууль, институтын 750, гадаад улс, Монгол Улсад суугаа элчин сайдын яам, олон улсын байгууллагын 50, нийт 800 гаруй төлөөлөгч оролцлоо. Монгол Улсад

шүүх эрх мэдлийн болон хууль зүйн салбарын шинэчлэл хийгдэж байгаа энэ цаг үед гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага, тулгамдсан асуудлыг онолын түвшинд хөндсөн 50 гаруй илтгэлийг уг хурлын үеэр хэлэлцүүлсэн. Хурлаас гаргасан зөвлөмжийг Хууль зүйн сайдад хүргүүлж, эмхэтгэл болгон гаргаж нийтийн хүртээл болгосон билээ.

Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан “Хууль сахиулах салбарын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт салбарын хэмжээний эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, ХСИС-ийн 2013 оны “Тэргүүний судлаач эрдэмтэн”, “Тэргүүний судлаач багш”, “Тэргүүний судлаач докторант”, “Тэргүүний судлаач магистрант”, “Тэргүүний судлаач сонсогч”-ийг шалгаруулав.

Цагдаагийн сургууль “Онцгой байдлын үед төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа”, ШШҮХ-тэй хамтран “Утаслаг эдлэлд үүссэн гэмтэлд хийх шинжилгээг боловсронгуй болгох нь”, Хилийн сургуулиас “Улсын хил хамгаалалтад тулгамдаж буй зарим асуудлууд”, Ерөнхий эрдмийн сургууль “Гадаад хэл ба өнөө үе”, “Сонсогч оюутны сонсох чадвар ба түүнийг хөгжүүлэх асуудал”, “Гадаад хэл заах сэтгэл зүйн зарим асуудал”, “Хууль сахиулах байгууллагуудын сэтгэл зүйн ажлын өнөө ба хэтийн төлөв” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулиас ШШГЕГ-тай хамтарсан “Эрх зүйн шинэтгэл ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг, Удирдлагын сургуулиас “Хил орчимын бүс нутагт тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа” сэдэвт команд штабын сургалтыг тус тус зохион байгуулсан.

Багш нарыг ажлын байран дээр нь хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд идэвх сонирхлыг өрнүүлэх зорилгоор сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, хичээлийн нэр томьёоны багц, бие даалтын сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтын үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээ, SWOT шинжилгээ хийх, хичээлийн индекс боловсруулах, блок сургалтын санал боловсруулах зөвлөмжийг боловсруулж, “Багшийн хөгжил” цуврал сургалтыг үе шаттай зохион байгуулж байна.

Удирдлагын сургуулийг түшиглэн мэргэжлийн 4 чиглэлээр профессорын баг байгуулж, ажиллуулж эхлээд байгаа бөгөөд Хилийн сургуулийн мэргэжлийн чиглэл бүрээр “Профессорын зөвлөх баг”-ийг байгуулан “Нэгдсэн хичээл”-ийн хэлбэрийг сургалтад нэвтрүүлэхээр ажиллаж байна.

“Гэмт хэргийг илрүүлэхэд гарын мөрийн Папилон санг ашиглах нь”, “Полиграф ашиглан явуулах сэтгэц физиологийн шинжилгээний үр дүнг үнэлэх нь” сэдвээр ОХУ-аас мэргэжлийн багш, эрдэмтдийг урьж ирүүлэн Хууль зүйн яамны холбогдох агентлагуудын ажилтнууд болон мэргэжлийн тэнхимийн багш нарын дунд сургалт зохион байгуулж, ОХУ-аас 2

ширхэг полиграф захиалан авч, сургалтад хэрэглэж байна.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхээр Хууль зүйн сайдын баталсан төлөвлөгөөнд тусгагдсан “Салбарын инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр, хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний төсөлд тусгасан, 2015 оноос эхлэн хэрэгжүүлэх “Цахим хянагч”, “Полиграф”, “Өндөр” (нисэгчгүй нисэх аппарат), “Хууль сахиулагч-Бага оврын нисдэг тэрэг” туршилт, судалгааны төслийн саналыг ХЗЯ-нд хүргүүлж, Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хоёр. Их сургуулийг судалгааны их сургууль болгож хөгжүүлэх чиг хандлага, үзэл баримтлал

А. Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын талаарх хөгжлийн үзэл баримтлал чиг хандлага:

Монгол Улсын Их хурал 1998 онд “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг баталсан бөгөөд түүнийг удирдлага болгон Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлж байгаа билээ. Уг Мастер төлөвлөгөө нь Монгол Улсад шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх, улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогод нийцсэн стратегийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, тэргүүний технологийг нэвтрүүлэх, шинжлэх ухааны чадавх, нөөцийг улс, эх орны хөгжлийг хангах үндсэн хүчин зүйл болгох, судалгаа боловсруулалтын тогтвортой үйл ажиллагааг бий болгон хөгжүүлэхэд чиглэж байна.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “судалгаа, шинжилгээний ажлыг их, дээд сургууль болон бодлогын институт дээр төвлөрүүлж, Шинжлэх ухаан, технологийг дэмжих сангийн санхүүжилтийг энэ зорилготой уялдуулах” талаар заасан билээ. Дээрх бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн заалтыг хэрэгжүүлэхийн тулд их сургуулиас “Судалъя-шийдье-бүтээе” гэсэн уриаг дэвшүүлж, суралцагчаас удирдлага хүртэл судлаач байх, сайн судлаач багш, суралцагч хөтөлбөр хэрэгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн тодорхой төсөл хэрэгжүүлэх, профессорын багаар дамжуулан багш нарыг эрдэмжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэлээр гадаад, дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний судалгааны орчин үеийн арга, туршлага судалж, нэвтрүүлэх, төлөвлөгөөт болон захиалгат судалгааг онол, арга зүй, практик туршлагад үндэслэн чанартай гүйцэтгэх шаардлага тулгамдаж байна.

Орчин үеийн их сургууль “мэдлэгийн менежмент”-

ийг хэрэгжүүлэх замаар: мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөц бэлтгэж, хөдөлмөрийн зах зээлд санал болгох, шинжлэх ухааны агууламж бүхий шинэ технологийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, ажлын арга (know-how)-ын талаар зөвлөгөө өгөх, хэвлэн нийтлэх, сургалт явуулах болон бодлого боловсруулах үйлчилгээ үзүүлэх чиглэлээр эрдмийг “мөнгө” болгон хувиргаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилж, Засгийн газраас боловсруулан Улсын их хурлаас баталсан Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлогод “цаашид нийгэм, эдийн засгийн бүх хүрээнд инновацийн хандлага улам бүр онцгой үүрэг гүйцэтгэж, мэдлэгт суурилсан эдийн засаг гол капитал байх” хэмээн дүгнэж шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн тэргүүлэх зорилтыг тодорхойлсон байдаг.

Тиймээс бид Хууль сахиулах инновацийн бодлогыг хэрэгжүүлэх буюу хууль сахиулах үйл ажиллагаанд тэргүүний дэвшилтэд технологийг эрчимтэй нэвтрүүлэх замаар гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах ажлын үр дүнг үлэмж дээшлүүлэх бодит шаардлага тулгарч байна. Тухайлбал, полиграф, профайлинг, crime mapping-ийн арга зүйг ашиглах, цахим хяналтын хэрэгсэл (электрон гав, CCTV), нисэгчгүй нисэх аппарат, тейзер гар буу зэрэг орчин үеийн техникийг судалж, туршин практикт нэвтрүүлэх ажлыг тус их сургуулийн эрдэмтэн, судлаачид тодорхой төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Тус их сургуульд хууль сахиулах байгууллагын захиалгаар шинжилгээ, судалгаа хийдэг эрдэм шинжилгээний бүтэц, тухайлбал, гарын мөрний адилтгалын автомат систем “Папило”, ДНХ-ийн шинжилгээний болон дүрс, авиа судлалын лаборатори, нөхцөл байдлын шинжилгээний лаборатори, полиграфологийн төв, гамшиг судлалын болон хил хамгаалах техник зүйн лаборатори, профайлингийн кабинет зэргийг байгуулах арга хэмжээг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэх болно.

ХСИС-ийн бүтэц дэх эрдэм шинжилгээ, сургалтын болон дэмжлэг үзүүлэх албаны зохистой харьцааг оновчтой тогтоон, сонгодог их сургуулийн бүтэц рүү аажим шилжиж, судалгааны их сургууль болсноор үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах үйл ажиллагааны чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа хийх, их сургуулийн инновацийн бодлогыг тодорхойлох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд мэдэгдэхүйц ахиц гаргах болно.

Хууль зүйн яам, түүний харьяа агентлаг болон захиалагч байгууллагын үйл ажиллагааны шинжлэх ухааны хангамжийг нэгдсэн бодлогоор дагнан хариуцаж, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд эрдэм шинжилгээ, сургалтын ажлын үр дүнг нийцүүлснээр

хууль сахиулах бодлогыг амьдралд тууштай хэрэгжүүлэх бодит боломж бүрдэнэ.

Эдгээр зорилтыг ханган биелүүлэхийн тулд шинжлэх ухаан, технологийн дэд бүтцийг хөгжүүлэх, төгсөлтийн дараах сургууль байгуулж, эрдмийн зэрэг, цолтой мэргэшсэн судлаачдыг бэлтгэх замаар ХСИС-ийн эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын ажлыг төгөлдөржүүлнэ.

Б. Их сургуулийн Шинжлэх ухаан, технологийн газраас хэрэгжүүлэх бодлого, баримтлах чиглэл

Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр өгсөн ярилцалагад: “Сургуулиуд орлогынхоо ядаж 50 хувийг эрдэм шинжилгээний ажлаас олж байдаг баймаар байна. Өнөөдөр эрдэм шинжилгээний ажил хийснээр нь бус хичээл зааснаар нь багш нарынхаа цалинг олгодог. Цаашид их сургуулиуд хичээл заахаас гадна эрдэм шинжилгээний ямар ажил хийв гэдгийг нь үнэлдэг, тэр үнэлгээгээр санхүүжилт нь шийдэгдэж байдаг байгууллага болж хөгжих ёстой” гэж их сургуулиудын хөгжлийн чиг хандлагын талаар тодорхойлон хэлсэн. Тиймээс бид дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээ, ажлыг ойрын үед хийх болно. Үүнд:

- ХСИС-ийн судлаач, багш, алба хаагчдыг эрдэмжүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар эрдмийн зэрэг, цолтны эзлэх хувийн жинг эрс нэмэгдүүлнэ.
- Төр засаг, хууль зүйн яам, түүний харьяа агентлагуудын захиалгат судалгааг шинэ технологиор хугацаанд нь чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх, түүний үр дүнд тулгуурлан арга зүйн зөвлөмж, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулж ажиллана.
- Эрдэм шинжилгээний хурал, семинар, симпозиумыг шатлалтай зохион байгуулж, шинжлэх ухаан, практикийн тодорхой салбарт инновацийг идэвхтэй нэвтрүүлнэ.
- Хууль сахиулах үйл ажиллагаанд орчин үеийн шинэ техник, технологи, аргыг судлан нэвтрүүлэхэд санаачлага гарган ажиллана.
- Их сургуулийн Шинжлэх ухаан, технологийн газрыг Үндэсний эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн болгон оновчтой бүтэцтэйгээр өргөтгөн зохион байгуулна.
- Хүрээлэнгийн бүтцэд туршилт, шинжилгээ, судалгааны орчин үеийн лабораториуд байгуулан, ашиглалтад оруулна.
- Дотоод, гадаадын эрдэм шинжилгээний байгууллагатай ажил хэргийн холбоо харилцаа тогтоон, судалгааны шинэ арга хэлбэрээр хамтарсан судалгаа хийж, бүтээл туурвин, судлаач солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж эхэлнэ.
- ХСИС-ийн бэлтгэдэг үндсэн мэргэжил бүрээр сурах бичигтэй болох хөдөлгөөн өрнүүлж, үр дүнг тооцож ажиллана.
- Олон улсын болон үндэсний хэмжээний хөтөлбөр,

төсөл, төлөвлөгөөт ажлыг профессорын багуудаар дамжуулан хэрэгжүүлэх замаар ХСИС-д эдийн засгийн үр ашигтай тогтолцоо бий болгон төлөвшүүлнэ.

- Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулж, эрдэмтдийн тоог, чанарын хамт нэмэгдүүлэх, багш нараа докторын зэрэг хамгаалах шаардлага тавьж, дэмжлэг үзүүлэх.
- ХЗЯ-ны харьяа агентлагуудаас заавал захиалгат судалгааны ажил гүйцэтгэх бодлого барих, гадны байгууллагын захиалгаар судалгаа хийх, санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, хүрээлэнг өөрсдөөр нь чадавхжуулах, судлаачдыг бие даасан байдлаар хөгжүүлэх болно.

Дээрх хөгжлийн бодлого, үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр сонгодог их сургуулийн загвараар хөгжих, судалгааны их сургууль болж шинжлэх ухааны чадавхиа нэмэгдүүлэх, өндөр ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх, хууль сахиулах байгууллагын тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

АШИГЛАСАН ЭХ МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, УБ. 2012 он
2. Монгол Улсад Үндэсний Инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр /2008-2015/ Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 306 дугаар тогтоолын хавсралт
3. Шинжлэх ухаан технологийн талаар төрөөс баримтлах бодлого, УБ. 1998 он
4. Монгол Улсын шинжлэх ухаан технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, УБ.2006 он
5. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 48 дугаар тогтоол, УБ. 2010 он
6. Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль, УБ. 2002 он
7. Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, УБ. 2006 он